



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations



International
Labour
Organization





“Монгол Улсад Тогтвортой Хөгжлийн Зорилготой уялдсан төсвийн
төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл

Agripreneurship Challenge

Хүнс, ХАА-н салбарын инновацлаг
бизнес шалгаруулах тэмцээн

УДИРДАМЖ



АГУУЛГА

1. ЗОРИЛГО
2. ХАМРАХ ХҮРЭЭ
3. ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ШААРДЛАГА
4. ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ҮЕ ШАТ, ХУГАЦАА
 - 4.1. Бүртгэл
 - 4.2. Бүрдүүлэх материал
5. ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ ШАЛТГААН



1. ЗОРИЛГО

Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас хэрэгжүүлж буй “Монгол Улсад Тогтвортой Хөгжлийн Зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд “Agripreneurship Challenge” хүнс, хөдөө аж ахуйн салбарын шинэлэг бизнесүүдийг шалгаруулах уралдааныг зарлаж байна.

Тус уралдаанаар дамжуулан төслийн хүрээнд бойжуулах хүнс, хөдөө аж ахуйн салбарын шинэлэг шийдэл болон бүтээгдэхүүнийг тодруулахаар зорьж байна.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү уралдаанд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа хүнс, хөдөө аж ахуйн салбарт инновацлаг бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж буй бизнес эрхлэгчид оролцох боломжтой.


3. ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Шинэлэг болон инновацлаг шийдэл эсвэл бүтээгдэхүүнтэй байх.
2. “Minimum Viable Product” (MVP) бүтээгдэхүүний загвараа гаргасан байх.
3. Аж ахуйн нэгжийн бүртгэлтэй, 5 буюу түүнээс доош жил үйл ажиллагаа явуулж байгаа
4. Төсөл хэрэгжих хугацаанд сургалт, хөтөлбөрт идэвхтэй хамрагдах.
5. Цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах, тууштай байх.

Тайлбар: Экспортонд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй бол давуу тал болно.



4. ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ҮЕ ШАТ, ХУГАЦАА



4.1. Бүртгэл

Бүртгэл 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 23:00 цаг хүртэл (Улаанбаатарын цагаар) явагдана.

4.2. Бүрдүүлэх материал

- Анкет бөглөх: <https://forms.gle/7LxrbBh3iSiap1Gr7>
- Улсын бүртгэлийн гэрчилгээ
- Компанийн танилцуулга /цаашдын дор хаяж 5 жилийн төлөвлөгөөний хамтаар/
- Бүтээгдэхүүний танилцуулга, зураг

Тайлбар: Ирүүлсэн материалыг сонгон шалгаруулж тэнцсэн 20 бизнес рүү бүүткэмп хөтөлбөр зохион байгуулагдахаас 7 хоногийн өмнө утсаар мэдэгдэнэ.



5. ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ ШАЛТГААН

- Бизнесийн өсөлтөд тань нэн шаардлагатай олон улсын болон дотоодын экспертүүдээс зөвлөгөө, көүчинг авах. Үүнд:
 - Санхүүгийн менежмент, хөрөнгө оруулалтын харилцаа
 - Тогтвортой, хариуцлагатай бизнесийн загварууд
 - Брэндинг болон маркетинг
 - Экспортын замын зураглал, баримт бичгийн бүрдүүлэлт
 - Хөрөнгө оруулалтын питч танилцуулга
- Тус салбарт үйл ажиллагаа явуулж буй амжилттай бизнесүүдтэй холбогдож, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх

6. ШАГНАЛЫН САН

- Нийт шагналын сан 50 сая хүртэлх төгрөгийн хөрөнгө оруулалтын дэмжлэг. Үүнд:
 - I байр - 25 сая төгрөг хүртэл
 - II байр - 15 сая төгрөг хүртэл
 - III байр - 10 сая төгрөг хүртэл
- Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас хэрэгжүүлж буй “Монгол Улсад Тогтвортой Хөгжлийн Зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд нэг жилийн хугацаанд олон улсын болон мэргэжлийн дотоодын зөвлөхүүдээс зөвлөгөө авах, бизнесээ бойжуулах боломж;

ТӨСЛИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Монгол Улсад Тогтвортой Хөгжлийн Зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл нь Монгол Улсын Засгийн газартай хийсэн гэрээний дагуу Европын Холбооноос үзүүлж буй Хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлд зориулсан Төсвийн дэмжлэгийн Техникийн туслалцааны бүрэлдэхүүн хэсэг юм. Энэхүү техникийн туслалцааны төслийн ерөнхий зорилго нь Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд оршино. Түүнчлэн хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн салбарт төрийн үйлчилгээг үр дүнтэй, хариуцлагатай, шуурхай хүргэх; төсөв, санхүүгийн удирдлагын (ТСУ) тогтолцоог сайжруулах, институтын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг зорьж байна. Төслийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага хамтран хэрэгжүүлдэг. Засгийн газрын түвшинд Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай түншлэн ажилладаг.

ХОЛБОО БАРИХ

Утас: 91916987, 95077178

